


2014.7.15

Дугаар 8

 **Жайка-гийн Буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааны хүрээнд хүн ам ихээр төвлөрсөн томоохон хот, аймгуудад барьж байгуулсан нийт 55 сургуулийн байгууламжийн тухай**

 **Project E-News**


【Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал - Төсөл】

Төслийн удирдах ажилчин Э. Анхцэцэг

 **Volunteer E-News**

【“Өсвөр үеийн хөгжлийн ажилтан”-р ажиллаж байгаа Жайка-гийн Сайн дурын гишүүдийн сэтгэгдлээс】

Сайн дурынхныг хариуцсан ажилтан Э. Золбоо

 **Сургалт төгсөгчдийн булан**

【Жайка-гийн сургалтанд оролцсон Монголын хамгийн анхны суралцагчийн сэтгэгдэл】

Хөдөө аж ахуйн хүний нөөцийг бэхжүүлэх сургалт(1989 он)-нд оролцсон

Н.Загдраднаа

Бэлтгэсэн : П. Алтансүх

Жайка Монгол дахь төлөөлөгчийн газар
Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3,
Улаанбаатар хот
Утас: 976-11-325939, 312393
Факс: 976-11-310845
E-mail: mg_oso_rep@jica.go.jp
<http://www.jica.go.jp/mongolia/index.html>


Монгол хүнд хамгийн их дотно сэтгэгдэл төрүүлсэн Жайка-гийн хамтын ажиллагаа ?

Япон улсын засгийн газар нь Буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хот болон хүн ам ихээр төвлөрсөн томоохон хот, аймгуудад нийт 55 сургуулийн байгууламжийг барьж хүлээлгэн өгсөн. Монгол улсын хүн амын дийлэнх хувь нь залуучууд бөгөөд төрөлтийн хувь харьцангуй өндөр байдаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд алслагдсан хөдөө орон нутгаас хот суурин газарт суурших шилжилт хөдөлгөөнийг дагаад хүүхдийн тоо ихэссэнээр сургууль, улмаар анги танхим хүрэлцэхгүйн улмаас 2 хүүхэд суудаг суудалд 3 хүүхэд суух жишээний ирээдүйн Монгол орны хувь заяаг авч явах хүүхэд багачуудын сурч боловсрох орчин бүрэлдээгүй нөхцөл байдал бий болсон.

Тиймээс 1999 оноос 2013 он хүртэлх хугацаанд Монгол улсын хот суурин болон хүн ам суурилсан томоохон аймгийн төвүүдэд нийт 55 сургууль (Улаанбаатар хотод 45 сургууль) барьж, хүүхэд багачуудад сурч боловсрох таатай орчинг бүрдүүлж өгсөн. Хэрвээ ойр хавьд чинь Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар барьсан сургууль байвал заавал очиж үзээрэй. Анги танхимын тохиолтоос ахуулаад сургууль доторх шатны суурьлуулалт, шалны материалд дуу чимээ бага гардаг материалыг ашиглах зэрэг өдрийн ихэнх цагийг сургууль дээрээ өнгөрөөдөг хүүхэд багачуудад аль болох таатай орчинг бүрдүүлэхийг эрмэлзсэн.



Мөн зөвхөн сургууль бариад зогсохгүй багш нарын заах арга зүйг сайжруулах техникийн хамтын ажиллагааг 14 жилийн турш хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ бүхнийг нэгтгэн харуулсан нэвтрүүлэг хийж, NTV зэрэг телевизээр олон нийтэд мэдээллэсэн. Боловсролын салбар нь аливаа улс эх орны хувь заяаг авч явах боловсон хүчнийг бэлтгэдэг хамгийн чухал салбар тул өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн хамтын ажиллагаа нь олон хүнд үр өгөөжөө өгсөн байх гэж найдаж байна.



Нэвтрүүлгийг телевизийн зөвшөөрлийг авсаны үндсэн дээр YouTube-д оруулсан тул доорх линкээр орж үзээрэй.

(Бүтэн эхээр) <http://youtu.be/pEvaZBTZPHQ>

(Богингосон) <http://youtu.be/ApbBMzBI6rA>

Facebook: <https://www.facebook.com/pages/JICA-Mongolia#!/pages/JICA-Mongolia/638581722827332>

Жайка-гийн Буцалтгүй тусламжийн хамтын ажиллагааны хүрээнд хүн ам ихээр төвлөрсөн томоохон хот, аймгуудад барьж байгуулсан нийт 55 сургуулийн байгууламж

Баянзүрх дүүрэг

Шавь цогцолбор сургууль

- Амгалан цогцолбор сургууль
- 79-р сургууль
- Хужир булангийн 120-р сургууль
- 13-р сургууль
- 92-р сургууль
- 48-р сургууль
- 68-р сургууль
- 87-р сургууль
- 97-р сургууль
- 14-р сургууль
- 33-р сургууль
- 44-р сургууль

Баянгол дүүрэг

- 19-р сургууль
- 28-р сургууль

Сүхбаатар дүүрэг

- 35-р сургууль
- 58-р сургууль
- 116-р сургууль

Сонгино хайрхан дүүрэг

- 12-р сургууль
- 121-р сургууль

- Тахилтын сургууль(Албан бус нэр)
- Баянголын сургууль(Албан бус нэр)
- 62-р сургууль
- 65-р сургууль
- 67-р сургууль
- 76-р сургууль
- 9-р сургууль
- 105-р сургууль
- 112-р сургууль
- Ирээдүй цогцолбор сургууль
- 115-р сургууль

Хан-Уул дүүрэг

- 52-р сургууль
- 118-р сургууль
- 60-р сургууль
- Цэцээ цогцолбор сургууль
- 114-р сургууль

Чингэлтэй дүүрэг

- 72-р сургууль
- 37-р сургууль
- Сэтгэмж цогцолбор сургууль

- 61-р сургууль
- 39-р сургууль
- 17-р сургууль

Багахангай дүүрэг

- 94-р сургууль

Налайх дүүрэг

- Голомт цогцолбор сургууль

8. Багануур дүүрэг

- Боловсрол цогцолбор сургууль

Дархан-Уул аймаг

- 2-р сургууль
- 6-р сургууль
- 7-р сургууль

Орхон аймаг

- 3-р сургууль
- 16-р сургууль
- 17-р сургууль
- 18-р сургууль
- 4-р сургууль
- 11-р сургууль
- Од сургууль

Project E-News

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал

Сүүлийн жилүүдэд Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудлын зорчигч үйлчлүүлэгчийн ачаалал эрс нэмэгдэж, 2006 оны статистикаар жилд 460 мянган хүн уг буудлаар үйлчлүүлж байсан бол 2013 оны байдлаар энэ үзүүлэлт 1 саяас даваад байна. Дотоод гадаадын олон мэргэжилтнүүдийн дүгнэснээр одоогийн нисэх буудал нь газарзүйн байрлалын хувьд хязгаарлагдмал буюу зурвасын урд талаас өндөр уулын саадтай тул зөвхөн нэг талаас хөөрөлт бууралт хийх боломжтой байдаг. Мөн цаг агаар тааламжгүй, хүчтэй салхитай улиралд нислэг саатах, бууж чадахгүй байх тохиолдол нэлээд гардаг. Иймээс эдгээр бэрхшээлийг цогцоор шийдвэрлэх, улмаар өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах зорилгоор газарзүйн хувьд тохиромжтой байрлалд дэлхийн жишигт нийцсэн, үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг хангасан нисэх буудлыг шинээр барих төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн юм. Ингээд Япон улсын Засгийн газарт хүсэлт тавьсны дагуу тус улсын Засгийн газраас хөнгөлөлттэй зээл олгох шийдвэр гаргаж, 2008 онд хоёр улсын Засгийн газар хоорондын зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурсан билээ. Нисэх буудлын барилгын ажлыг 2013 оноос эхлүүлж, 2017 он гэхэд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

2013 оны 2-р сард УИХ-аар батлагдсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичигт зааснаар олон улсын стандарт шаардлагад нийцсэн, нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангасан, өрсөлдөх чадвар бүхий иргэний нисэхийн үйлчилгээг бий болгох, Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг Хойд Азийн зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа болгохоор зорьж байгаа тул уг нисэх буудал нь Монгол улсын хувьд нэн чухал ач холбогдол бүхий томоохон дэд бүтэц болох юм.

Шинэ нисэх буудлын үндсэн үзүүлэлтүүд

Төслийн нэр	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал
Захиалагч	Иргэний Нисэхийн Ерөнхий Газар
Нисэх буудлын байршил	Улаанбаатар хотоос урагш 50км, Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Хөшигийн хөндий
Хөөрч буух зурвасын хэмжээ	3,600м×45м
Зорчигч үйлчилгээний барилгын талбайн хэмжээ	33,300м ² (3 давхар)



Зорчигч үйлчилгээний барилгын ажил



Хөөрч буух зурвас



Барилгын ажил

Гүйцэтгэгч: Мицүбиши болон Чиёода компаниудын түншлэл

Зөвлөх : Азуса Сэkkэй/Ориентал Консалтантс компаниудын түншлэл

Гүйцэтгэгчийн гэрээний хугацаа : 43 сар (2017 оны 1-р сарын 7 хүртэл)

Барилгын ажлын цар хүрээ:

- Зорчигч үйлчилгээний барилга : 33,300 м² , 3 давхар, ган болон төмөр бетон хийцтэй
- Нислэг хөдөлгөөний удирдлагын цамхаг : 38м, 4 давхар, ган болон төмөр бетон хийцтэй
- Хөөрч буух зурвас : урт нь 3,600м, өргөн нь 45м

Volunteer E-News

Энэ удаа “Өсвөр үеийн хөгжлийн ажилтан”-р ажиллаж байгаа Жайка-гийн Сайн дурын гишүүний тухай танилцуулна.

Хүлээн авагч байгууллагын сэтгэгдэл①: Завхан аймаг, Хүүхэд-Гэр бүлийн хөгжлийн газрын дарга Мягмарсүрэн.

Завхан аймгийн Хүүхэд-Гэр бүл хөгжлийн газарт “Өсвөр үеийн хөгжлийн ажилтан”-аар Жайка-гийн Сайн дурын гишүүн Оода Юми томилогдон ажиллаж байгаа билээ.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй Хүүхдийн төлөөх байгууллагуудад хандан хүүхэд багачуудын оролцоог идэвхижүүлэх хамтын ажиллагааг эрчимжүүлж, япон дахь ижил чиглэлийн үйл ажиллагааны сайн жишээг ашиглан олон төрлийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Жишээлбэл байгаль орчинг хэрхэн хайрлаж хамгаалах, цэвэр цэмцгэр хоггүй байлгах асуудлыг хөндсөн идэвхижүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.

Улмаар Японы цаасан урлалын дугуйлан хичээллүүлж, Япох орны ёс заншил, уламжлалыг зааж танилцуулдаг. Мөн сургууль, цэцэрлэг зэрэг боловсролын байгууллагуудаас Юмийг урьж ажиллуулах хүсэлт тавихаас гадна Завхан аймгийн Хүүхэд-Гэр бүлийн хөгжлийн газрын удирдах ажилчдын зүгээс сайн дурын ажилтан хүлээн авах хамтын ажиллагааны хэлбэрт өндөр сэтгэгдэлтэй байдгийн дээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг өндөрөөр үнэлдэг юм. Гэхдээ бид бүгдийн үнэлэлт дүгнэлтээс илүүтэйгээр өдөр бүр ойр дотно байдаг хүүхэд багачуудад хайрлагдаж байгаа нь илэрхий байдаг.

Хамгийн сүүлд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас танилцуулахад өнгөрсөн 6 сарын 1 өдөр буюу Хүүхдийн баяраар Юмигийн санаачилгаар “Байгаль орчинд ээтлэй өдөр” сэдэвт баярын өдрийг өнгөрүүлсэн. Удахгүй болох Завхан аймгийн хүүхдийн дээд эрх барих 29-р чуулган эхлэх гэж байгаатай холбогдуулан 300 гаруй хүүхэд багш нарт хандан “Тол усыг хэрхэн бохирдуулахгүй байх, байгаль орчиноо хайрлан хамгаалах” сэдвээр сургалт сурталчилгааг хийхээр бэлтгэж байгаа. Юми манай байгууллагын өдөр тутмын ажилд бие сэтгэл гарган оролцохоос гадна завхан аймагт ажиллаж байгаа бусад сайн дурын гишүүдээ өсвөр үеийн хөгжлийн төлөөх үйл ажиллагаанд татан оролцуулж хамтарч ажилладаг нь сайшаалтай байдаг. Төгсгөлд нь бидэнтэй сайхан хамтарч ажиллаж байгаа Юми болон Жайка төлөөлөгчийн газарт талархаж байгаагаа илэрхийлэхэд таатай байна.

Бид бүхэн цаашид ч гэсэн сайн дурын гишүүдтэй хамтарч ажиллах хүсэлтэй байна.

Хүлээн авагч байгууллагын сэтгэгдэл②: Хархорин сум, Орхон цогцолбор сургуулийн Нийгмийн ажилтан Д.Долгормаа.

Өнгөрсөн оны 11-р сард Японы сайн дурын гишүүн Тамай-Ёшиэ манай сургуульд 2 жилийн хугацаатай ажиллахаар ирсэн. Ирээд сум сургуулийн үйл ажиллагаатай танилцаж орон нутгийн давуу тал дээр тулгуурлан өөрийн хийх ажлын ерөнхий чиглэлийг тодорхойлсон. Манай сумын хувьд эсгий урлал, шүр сувсан урлалын бүтээл их хийгддэг. Ёшиэ эдгээр урлалыг их сонирхсон хийж сурахын зэрэгцээ бидэнд Японы уламжлалт урлагийн нэг болох цаасан оригами хийх аргыг зааж өгдөг. Энэ сургалт маш амжилттай явагдаж байгаа.

Сургуулийн багш ажилчид нар ч гэсэн түүнийг халуун дотноор хүлээн авч, өндөр хөгжилтэй орны иргэн гэдэг утгаар амьдрах байр, хичээллэх анги танхимын тав тухтай байх тал дээр ихээхэн санаа тавьдаг. Гэхдээ Ёшиэ маань амьдарч байгаа орчиндоо маш хурдан дасан зохицох чадвартай бөгөөд ямарч нөхцөлд хүнтэй харьцаж, ойлголцож чаддаг. Бидэнд хэл амаа ойлголцохгүй байх хүндрэлтэй асуудал гардаггүй. Цаг маш сайн барьдаг. Ажил хариуцуулахад сэтгэлээсээ үнэнч хийж, их хичээнгүй байдаг тул бидний хувьд хамтран ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг.

Ёшиэ анги удирдсан багш нартай хамтран ажиллаж цэцэрлэг, бага, дунд ангийн 18 бүлгийн 700 гаруй сурагчдад цаасан урлалын дугуйлангаар оригами хийхийг зааж өгч хийсэн бүтээлээрээ шинэ жилийн баярын танхимыг чимэглэсэн нь багш,эцэг эх, сурагчдын талархлыг хүлээсэн ажил болсон. Мөн дугуйландаа олон хүүхдийг хамруулснаар сурагчдын чөлөөт цагийг зөв өнгөрөөх, бие биеэсээ суралцах, авьяасаа хөгжүүлэх, хүүхдийг урамшуулах ажлыг хийж байгаа нь үр дүнтэй ажил болж байгаа гэж бид дүгнэж байгаа.



Жайка-гийн Сайн дурын гишүүнийг авч ажиллуулах тухай:

Сайн дурын гишүүнийг Монгол-Япон 2 улсын хоорондын гэрээнд үндэслэн томилдог бөгөөд тухайн байгууллагын хүсэлтэд үндэслэн харьяа яам болон Эдийн засгийн яам, Гадаад харилцааны яамуудаар дамжуулан шийдвэрлэдэг. Томилогдох салбарын тухайд Монгол улсын хөгжлийн стратеги болон Жайка-гаас Монгол улсад хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй уялдуулан сонгодог. Мөн Жайка-гийн Сайн дурын гишүүнээр томилох мэргэжилтний хувьд бусад Олон улсын байгууллагуудтай харьцуулахад сонголт ихтэй, маш өргөн хүрээг хамардаг.

Сайн дурын гишүүн шинээр хүсэх болон үргэлжлүүлэн хүсэлт тавьж буй албан газрууд нь доорх зааврын дагуу анкет материалаа бүрдүүлж холбогдох яам тамгын газарт хүргүүлнэ үү.

Үүнд :

1. ЖАЙКА-с өгөх сайн дурын гишүүн авах хүсэлтийн анкетийг бөглөх
2. Анкетаа бичиж эхний байдлаар ЖАЙКА-д шалгуулах, ЖАЙКА нь шалгаж үзээд эцсийн байдлаар бэлэн болсон тохиолдолд анкетын хамгийн доод талын хэсэгт тухайн хүсэлт гаргагч байгууллагын дарга, захирлын гарын үсэг тамга даруулж, албан бичиг хавсаргах
3. Анкетыг 4хувь хийж өөрийн байгууллагын харьяа яам тамгын газрын гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлж зөвшөөрөл авах. (яам бүр анкетийн нэг нэг хувийг авч үлдэнэ.)
4. Тухайн харьяа яам нь анкет болон дэмжих албан бичгээ Эдийн засгийн хөгжлийн яам эдийн засгийн хамтын ажиллагаа зээл тусламжын бодлогын газарт хүргүүлэх.
5. Анкет нь доорх дарааллын дагуу явагдана.

Хүсэлт гаргагч байгууллага нь анкетаа өөрийн харьяа яам тамгын газрын гадаад хамтын ажиллагааны хэлтэс → харьяа яам →Эдийн засаг хөгжлийн яам (Эдийн засгийн хамтын ажиллагаа, тусламжийн бодлогын газар) →Гадаад Харилцааны Яам →Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яам →Японы Гадаад Хэргийн Яам →ЖАЙКА-ийн төв рүү хүргэгдэн албан ёсоор хүсэлт тавигдах болно.

Сургалт төгсөгчийн булан

1989 оны төгсөгч Н.Загдраднаа

Миний бие Япон улсын Засгын Газрын урилгаар 1989 оны 3-р сараас 11-р сарын 24-нд Цүкүба (Шинжлэх Ухааны Төв) хот дахь Жайка-ийн салбар Хөдөө Аж Ахуйн Олон Улсын төвийг төгссөн анхны Монгол мэргэжилтнээр суралцах завшаан тохиож билээ. Тэр үед Монгол улс коммунист дэглэмтэй, гадаадтай ялангуяа гуравдагч орон Япон улстай зөвхөн дипломат шугамаар харилцдаг, гадаад худалдаа эдийн засгийн харилцаа хязгаарлагдмал, салбарын яамд болон аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн харилцаа төдийлөн эхлээгүй байсан.



Япон улсын зүгээс санаачлага гаргаж хөдөө аж ахуйн мэргэжилтэн нэг хүнийг сургаж дадлагажуулах саналыг манай талд ирүүлснээр миний бие сонгогдож суралцах завшаан тохиосон юм. Тухайн үед манай яам болон түүний харьяа байгууллагуудад сургалтын болзол, шаардлага хангасан инженер мэргэжилтэй хүн бараг байгаагүй, түүнчлэн нам төрийн удирдах дээд газруудаас “Япон улстай хөдөө аж ахуйн талаар хамтран ажиллах шаардлага бидэнд байхгүй” гэж хүртэл үзэж байсан тохиолдол байсан. Тийм л цаг үе байлаа. Одоо бол улс орон, цаг үе эрс өөрчлөгдөж Япон улсаас урилга зөвшөөрөл гэхгүйгээр Монголчууд мянга, мянгаараа аялдаг, зорчдог,

ажиллаж амьдардаг болсон, мэргэжил дээшлүүлж хэл соёлыг нь эзэмшиж ойртож нягтарсан жишээ олон бий.

Хаалттай нийгэмд зөвхөн Москвагаар дамжиж Токио хүрч байсан миний үе нэгэнт дурсамж болон хоцорч, өнөөдөр цаг хугацаа нь 10 дахин богиносож, зардал мөнгө 5 дахин хямдарч, хамтын ажиллагаа улам өргөжсөөр Монгол-Япон хоёр улс саахалт айлын дайтай ойрхон болжээ.

Жайка надад юу өгсөн бэ:

Япон орон, ард түмний амьдрал, ажил хөдөлмөр ялангуяа жирийн тариачнаас эхлээд үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай танилцуулж, хамтран ажиллаж хөгжил дэвшилд хүрэх замыг бидэнд зааж өгсөн гэж боддог. Япончууд биднээс юугаа ч нуугаагүй. Чөлөөтэй зорчиж түр оршин суух эрхийн үнэмлэх өгөхдөө “Улс төрийн үйл ажиллагаанд” оролцохгүй байхыг зөвлөөд бусад бүх юм таны өмнө нээлттэй, чөлөөтэй гэж хэлж байж билээ.

Хойд нутаг Хоккайдогийн тал, тариан талбайгаас эхлээд төв арлын ихэнх мужийн үйлдвэр, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, жирийн фермерийнд зочилж, будааных нь онцлогийг судлахаар Окинава орж, хэдийгээр Монголд тариалдаггүй ч чихрийн нишингийн тариалалтаа сонирхуулахаар алс өмнөд Ишигаки аралд хүртэл зочлууж танилцуулж байлаа. Үнэхээр их сэтгэл зүтгэл, хөрөнгө зардал гаргаж хөдөлмөр зарсан үйл ажиллагаа байв.

Жайкад суралцсаны үр:

Дэлхийн шинжлэх ухаан, техникийн ололт, Японы туршлагыг нүдээр үзэж судалж арга барил эзэмшсэнээр Монголдоо ирээд 1991-1996 онд хэрэгжүүлсэн Японы засгийн газрын буцалтгүй тусламж, техникийн хамтын

ажиллагааны Grant Aid KR1, KR2 төслүүд дээр ажиллаж үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд гар бие оролцсоноор миний судалж суралцсан нилээд зүйлүүд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж, малчдын хөдөлмөр, ахуйн нөхцөл сайжирч, орчин үеийн өндөр бүтээмжтэй техник технологи газар тариалангийн үйлдвэрлэлд нэвтэрч, хамтын ажиллагаа улам бүр гүнзгийрч байна.

1996-2000 онд Монголын Тариаланчдын холбоог байгуулалцаж гүйцэтгэх захирлаар ажиллах үедээ мөн өмнөх бодлого, үйл ажиллагаагаа үргэлжлүүлж ялангуяа мэргэжилтэн сургах фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд анхаарч байв. Энэ бүхэн бол Жайка-ийн ач тус, нөлөөгөөр хийгдсэн ажлууд юм.

Япон улсад суралцаж байсан тэр цагаас хойш 7,8 жилийн дараа 1997 оноос Жайкагийн төлөөлөгчийн газар Монголд байгуулагдаж, өнөөдөр олон мянган гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн Жайкагийн сургалт төгсөгчдийн холбоо нэлээд олон жил үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Би өөрийгөө Жайкагийн Монгол Пионерүүдийн нэг гэж бодож явдаг. Энэ нь ямар нэг гавьяа шагнал бус жирийн бодит түүхийн нэг хэсэг юм.